

АВЛИГА СОНГУУЛИАС ЭХЭЛДЭГ

А.Е. Клычков. Москва хотын думын гишүүн.
“Следователь” сэтгүүлийн 2013/4.

Орчуулсан: Н.Сайнаа

Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн,
Гадаад хэлний тэнхимийн ахлах багш, ахлах дэслэгч

Abstract: The article considers the peculiarities of corruption in the political sphere. The author has proposed legislative possible restrictions of electoral crime.

Улс төрийн салбарт гардаг авлигын онцлог

Сүүлийн жилүүдэд Оросын нийгэм, төрийн аппаратын авлига, хээл хахуулийн асуудал урьд нь байгаагүй түвшинд хүрээд байна. Авлига нь өөрийн сайн сайхан хангалуун байдлыг нэмэгдүүлэх зорилго бүхий эрх мэдлийн салаа мөчир бүхнийг нэг нэгдмэл төрийн аппаратад зангидах боллоо.

Улс төрийн салбарын хамгийн аюултай хэлбэр нь сонгуулийн үеийн авлига бөгөөд засаглалын бүхий л байгууллагад цаашид авлигын олон төрлийг бий болгож, улс төрийн элитүүдэд их хэмжээний материаллаг нөөцийг захиран зарцуулах, улс орны санхүү, эдийн засгийн бодлогыг тодорхойлох боломжийг олгодог.

Иргэдийн санаа зоригт ийнхүү хууль бусаар нөлөөлсний үр дүн нь нийгмийн янз бүрийн давхаргаас бүрдсэн, гажуудсан улс төрийн төлөөлөл бөгөөд энэ нь иргэд төр засагтаа үл итгэх байдал бий болгож улмаар улс орны амьдралыг зохицуулагч гол хэрэгсэл болсон хууль тогтоомжийн агуулга, ач холбогдол буурахад хүргэдэг.

Сонгуулийн авлига гэдэг нь өөрийн эрх мэдлийг хууль бусаар тогтоох зорилгоор сонирхогч этгээдүүд, улс төрийн хүнд сурталтнууд албан тушаалын байдлаа ашиглахыг хэлнэ. Сонгуульд нэр дэвшигчид санхүүгийн элитүүдийн тусламжтайгаар цаашид тэдэнд тохирсон шийдвэр гаргахад нөлөөлөх болзолтойгоор энэхүү бүрэн эрхийг албан ёсоор авахыг эрмэлздэг. 5-10 жилийн өмнө санхүүгийн лоббичид ихэнхдээ сүүдэрт, далд байдаг байсан бол сүүлийн жилүүдэд тэд өөрийн хүсэл зоригоо нуухгүйгээр үл барам санхүүгийн боломжоо ашиглан өөрсдөө эрх мэдэл бүхий байгууллагын албан тушаалд тэмүүлж төрийн өндөр албан тушаалтнуудын ивээлд ордог боллоо.

Сонгуулийн компанит ажилд бэлтгэх, зохион байгуулах явцад гарах авлига

Сонгуулийн явцад ОХУ-ын субъектуудын нутаг дэвсгэр, нийгэм эдийн засгийн онцлогийг харгалзан нийтээр, тогтмол ашигладаг сонгуулийн аргуудыг олон нийт мэднэ. Эдгээр аргууд нь сонгуулийн компанит ажлын үр дүнд захиргааны болон санхүүгийн хувьд нөлөөлөх боломжоор тодорхойлогддог бөгөөд ихэвчлэн хууль сахиулах байгууллага, сонгуулийн комиссын зүгээс халхавч болох нөхцөлийг хангаж өгдөг захиргааны нөөцийг ашигладаг.

Санал асуулгын үр дүнд хууль бусаар нөлөөлдөг гол аргад төрийн болон хараат нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевиз, радио, хэвлэл, интернет нөөцийг олноор ашиглахыг хамааруулан үзэж болно.

- Энэ нь юуны өмнө хэрэгтэй нэр дэвшигчиддээ илүү эфирийн цаг олгох, хэвлэлийн орон зайг ашиглах давуу эрх олгож, сөрөг улс төрийн хүчний нэр дэвшигчдийн эрхийг хязгаарлах, тэдэнд цаг олгохоос татгалзах зэргээр илэрдэг.
- Эрх баригч засгийн дэмжлэг бүхий нэр дэвшигчдийн дэс дараатай сурталчилгаа, тэдний өөрсдийн бие даасан сурталчилгаа нь бусад намын талаарх сөрөг дүр төрхийг иргэдийн дунд хүчтэй нэмэгдүүлдэг
- Албаны байр сууриа ашиглан өөрийн үйл ажиллагааг нийтийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах зорилгоор нийтийг хамарсан уулзалт, ярилцлага, арга хэмжээ зохион байгуулах зэрэг үүнд орно.

Хараат сонгуулийн комиссоор дамжуулан нэр дэвшигчдийг бүртгэхээс эхлээд санал асуулгын үр дүнг гаргах хүртэлх сонгуулийн бүхий л процесст авлига нөлөөлдөг. Улс төрийн өрсөлдөгчдийн сонгуулийн өмнөх компанит ажилд янз бүрийн аргаар саад хийх, нэр дэвшигчдийн сурталчилгааны материалыг хураах, эрүүгийн хариуцлагад татах, зарим нам, нэр дэвшигчдийн зөрчил булхайг нуун дарагдуулах зорилгоор сонгуулийн үйл явцад хяналтын болон хууль сахиулах, шүүх байгууллагуудыг идэвхтэй татан оролцуулдаг.

Албан ажлын байр, албаны холбооны болон тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, боловсон хүчин зэрэг материаллаг болон зохион байгуулалтын нөөцийг ашиглахын зэрэгцээ сургууль, эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, ОСНАА-н газруудыг ашиглан сурталчилгааны ажил өрнүүлж, сурталчилгааны материалаа түгээдэг.

Эрх баригч засгийн газар тэтгэвэр, тэтгэмж, бусад хөнгөлөлтүүдийг нэмэх замаар сонгогчдыг далд байдлаар худалдан авч, сонгуулийн сангийн хөрөнгийн зэрэгцээ санхүүгийн нэмэлт хэрэгслүүдийг ч өргөнөөр ашигладаг. Засгийн эрхэнд байгаа нэр дэвшигчид нь төсвийн хөрөнгийг шууд ашиглах явдал ч гардаг.

Сонгуулийн үеийн авилгыг хязгаарлах хууль эрх зүйн боломж

Сонгуулийн явцад авлигын нөлөөлөл гарахаас сэргийлэхийн тулд сонгуулийн процесст оролцож буй бүх субъект эрх баригч засгийн газраас хараат бус байх шаардлагатай бөгөөд үүний үр дүнд бүх улс төрийн нам, нэр дэвшигчдэд ижил тэгш нөхцөл бий болно.

Сонгуулийн комисс, шүүх, нийтийн мэдээллийн хэрэгслийн хуулиар тогтоосон тэрхүү хараат бус байдалд хэрхэн хүрэх вэ?

Нийтийн мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал

Энэ бол гол асуудлуудын нэг. Учир нь сонгуулийн компанит ажлаас бүр өмнө эрх баригч намын нэр дэвшигчид шаардлагатай мэдээллийн хэрэгслийн сууриа бий болгочихсон байдаг бол бусад намууд нь үүнийг өөртөө ч бараг байхгүй хэмжээний санхүүгийн зардал гаргаж байж бүрдүүлдэг. ОХУ-ын Ерөнхийлөгч Холбооны хурал дээр хийсэн сүүлчийн мэдэгдэлдээ ОХУ-ын субъектуудын эрх бүхий байгууллагуудыг зүй бус хөрөнгөнөөс ангижрахыг, өөрөөр хэлбэл төрийн байгууллага ямар ч үйлдвэр завод, сонин, усан онгоц эзэмших ёсгүйг сануулсан. Санаа нь зөв боловч үүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Эрх бүхий нам халхавч арилжааны бүтэц, үнэнч бизнесменүүдээ ашиглан хуурамч гэрээ байгуулах замаар татвар төлөгчдийн мөнгөөр сонгуулийн дараа мөн тэдэнд үнэнч байх амлалттайгаар намынхаа сурталчилгааг үргэлжлүүлэн хийлгэсээр байх болно. Ийнхүү төсвийн мөнгө ердөө нэг халааснаас нөгөө халаасанд орно гэсэн үг. Иймээс хамгийн үр дүнтэй арга нь бүх бүртгэлтэй намуудад төрийн мэдээллийн хэрэгсэл, сонин хэвлэлээр ард иргэдэд улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн талаар өөрсдийн үзэл бодол, мөрийн хөтөлбөрөө танилцуулах ижил хэмжээний цаг, орон зай олгох хэрэгтэй. Ийм хууль тогтоомж, санал санаачилга гарсан, хэрэгжиж байгаа ч хэрхэн хэрэгжиж байгаа, намуудын тэгш эрхийг хангаж байгаа эсэх нь эргэлзээтэй. Энэ хуульд олгогдсон эфирийн цагийн тоо,

чанарын үзүүлэлтийн талаар тогтоосон хэмжээ, оргил цагийн талаарх ойлголт зэрэг орхигдсон байгаа нь хуулийг хууль биш болгож байгаа юм.

“Улс төрийн намуудын үйл ажиллагааг нийтийн мэдээллийн хэрэгслээр тэнцвэртэй хүргэх баталгаа”-ны талаарх Холбооны хуулийг батлах явцад миний дээр дурьдсан ОКН намын бүлгээс санал болгосон нэмэлт өөрчлөлтүүд “Нэгдмэл Орос Намын” олонхийн саналаар унасан юм. Байдал ямар байна вэ гэвэл нэг талаас харахад тэгш байдал мөрдөгдөж байгаа, бүх намд ижил хэмжээний цаг оногдож байгаа мэт боловч аль нэг намын сурталчилгааг “хамгийн их үзэгчтэй” цагаар зуу дахин гаргаад, нөгөөг нь өглөөний 4 цагт ганц удаа үзүүлэх жишээтэй. Энэ хуулийн нэг шинэ нээлт нь тэгийн зарчим буюу тэгш байдал, өөрөөр хэлбэл нэг хэсэгт нь огт цаг байхгүй байлаа гээд бусад нь тийм байх албагүй. Төрийн өмчийн бус мэдээллийн хэрэгслүүдийн хувьд хууль тогтоох байгууллагуудын үйл ажиллагаа, тэдний гаргасан шийдвэрийг нийтийн хүртээл болгохдоо нэг мэдээллийн хөтөлбөрөөр бүлэг бүрийн санаа бодлыг дэс дараатайгаар тусгаж олны хүртээл болгодог давуу талтай.

Эрх баригч намаас нэр дэвшигчдийн албан тушаалыг ашиглах нь

2003 оноос хойш сонгуулийн талаарх хууль тогтоомжид орсон өөрчлөлтүүд нь нэр дэвшигчид, тэдний сурталчилгааны ажлын тэгш байдалд нөлөөлөхгүй байгаа. Тухайн хуульд эрх баригч засгийн газрын харьяа байгууллагуудаас зохион байгуулж буй уулзалт, арга хэмжээнд нэр дэвшигчид оролцох ёсгүй гэдгийг зааж өгөх хэрэгтэй. Нэр дэвшигчдийн хооронд шууд мэтгэлцээн заавал явуулах ёстой гэдгийг ч мөн оруулж өгөх нь зүйтэй. Иргэд зөвхөн эрх баригч намын давуу сурталчилгаа төдийгүй бусад улс төрийн намуудын төлөөллийн байр суурь, хөтөлбөрийг мэдэж байх эрхтэй.

Сонгуулийн компанит ажлын санхүүжилт ба сонгуулийн сангийн ашиглалт

Эрх баригч намаас нэр дэвшигчид болон бусад улс төрийн намаас нэр дэвшигчдийн сонгуулийн компанит ажилдаа зарцуулж буй хөрөнгийн хэмжээг харьцуулашгүй. Энэ бүхэн тогтсон сонгуулийн сангийн хөрөнгийн эргэлтэд орж тооцогддог. Иймээс түүний хэмжээ, хөрөнгө бүрдүүлсэн арга зэргийг эргэж харах нь зүйтэй. Хэрэв сонгуулийн сангийн хэмжээг хэд дахин бууруулаад олон нийтийн байнгын хяналттайгаар тухайн санг төсвөөс санхүүжүүлчих юм бол бүх нэр дэвшигчид ижил тэнцүү нөхцөлд өрсөлдөх боломжтой болно.

Сонгуулийн комиссыг бүрдүүлэх ба түүний үйл ажиллагаа

Сонгуулийн комисс нь гүйцэтгэх засаглалтай санхүү, зохион байгуулалтын хувьд нягт уялдаа холбоотой байдаг тул тэдэнтэй шударга байх талаар тооцоо хийх ямар ч үндэслэл байдаггүй. Сонгуульд оролцож буй бүх намаас ижил тэнцүү хэмжээний төлөөлөл сонгуулийн комисст ажиллах боломжтой. Ямар ч тохиолдолд сонгуулийн комиссын гишүүд эрх баригчдаас хараат бус байх ёстой.

Сонгогчийн үнэмлэхний ашиглалт

Сонгогчийн үнэмлэхийг хууль бусаар ашигласан эсэхийг тогтоох маш хэцүү. Сонгуулийн компанит ажил явагдах бүрт сонгуулийг зохион байгуулж буй сонгуулийн комисс сонгогчийн үнэмлэхний тоог нэмэгдүүлдэг. Үүний цаана хэн байгаа, нийтээр санал өгөх үед эрх баригч нам түүнийг өөрийн эрх ашигт хэрхэн ашиглаж буйг таамаглах боломжгүй. Харин сонгуулийн комиссын мэдэлд үүнийг өгөхгүйгээр тодорхой нутаг дэвсгэрт сонгогчдын тоонд харьцуулан сонгогчдын үнэмлэхний боломжит тоог хуулиар хязгаарлан тогтоож өгөх нь зүйтэй юм.

Санал өгөх, саналыг тоолох

Нэр дэвшигчдийн намын ажиглагчид, олон улсын ажиглагчдын эрхийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Сонгуулийн хэсэг дээр байгаа сөрөг намын ганц ажиглагч сонгуулийн комисст эрх баригч намаас томилогдсон гишүүн, нийгмийн дэг журам хангахаар ажиллаж буй хууль

сахиулах байгууллагын зүгээс дарамт шахалтад байнга ордог гэдгийг хэн бүхэн мэднэ. Сонгуулийн комиссын зүгээс ажиглагчийг хэсгээс явуулах нэг л хүсэлт гаргахад бусад төлөөлөгчид ямар үндэслэлтэй байсан ч түүнийг хүлээн зөвшөөрдөг. Үүнтэй холбоотойгоор санал асуулгын төдийгүй сонгуулийн комиссын үйл ажиллагааны бүх үйл явцад дүрс бичлэг хийх боломжийг хуулиар мэдээллийн хэрэгслүүдэд төдийгүй сонгуулийн процессын нийт оролцогчдод олговол илүү үр дүнтэй болно гэж үзэж байгаа юм.

Захиргааны технологи болон сонгуулийн үеийн авлигын эсрэг ажиллагаа

Бүх улс төрийн намууд, олон нийтийн хөдөлгөөний үйл ажиллагааг өргөнөөр сурталчилж улмаар иргэдийн улс төрийн талаарх мэдээллийн хүртээмж, нийгмийн идэвх, хариуцлагыг дээшлүүлснээр захиргааны нөөцийн эсрэг явуулах ажил үр дүнтэй болж чадна. Иргэдийн хурал, цуглаанд оролцох үндсэн хуулийн эрх, эрх чөлөөний зарчмыг хэрэгжүүлэх нь энэ чиглэлд гол үүрэгтэй. Нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах тал дээр бүх улс төрийн намуудад тэгш боломж олгох шаардлагатай.

2010 онд “Хурал, цуглаан, жагсаал, чимээгүй жагсаалын тухай” хуулинд Төрийн Думын олонхийн саналаар нэмэлт, өөрчлөлт оруулж нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулж явуулахад зарим нэмэлт хязгаарлалтуудыг тогтоож өгсөн. Холбооны энэхүү хуулийн дараа бүс нутгийн болон холбооны зарим субъектуудын талаархи хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж эхэлсэн. Иймээс бүсийн парламентууд дахь ОКН-ын бүлэг фракцууд бидний байр суурийг хамгаалж, гүйцэтгэх засаглалын санал болгосон хуулийн төслүүдээс захиргааны шинжтэй сааднуудыг авч хаях шаардлагатай.

Сонгуулийн үеийн авлигатай тэмцэх хуулийн нэмэлт боломжууд

Сонгуулийн үеийн авлигын тухай яриад бүсийн болон орон нутгийн хурлын дарга нарыг шууд сонгодог хэлбэрт буцаж орох шаардлагатай байгааг тэмдэглэхгүй орхигдуулж болохгүй юм. Сонгуулийн институтэд иргэд итгэхгүй байгаа нь өөрөө сонгуулийн авлигын суурь үндсийг бүрдүүлээд байгаа юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд төрийн дээд албан тушаалтнууд улс төрийн эр зориг гаргахгүйгээр дээр дурьдсан хууль тогтоомжуудыг өөрчлөх санал хэрэгжих боломжгүй. Өнөөгийн байдлаар эрх баригч намын оруулж буй санал санаачилгаас харахад энэ зүйл хийгдэхгүй нь тодорхой байна. Олон нийт, сөрөг улс төрийн намууд иргэдийн нийгмийн идэвх хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор зарим нам, улс төрийн хүчин хууль тогтоомж зөрчин, захиргааны аргаар сонгуулийн үр дүнд нөлөөлдөг гэдэгт олон нийтийн анхаарлыг хандуулах нь сонгуулийн үеийн авлигын эсрэг хийж чадах ганц зүйл болоод байна.